Урт хугацаат өр төлбөр: Төрийн болон орон нутгийн өмчөөр эх үүсвэрийг шийдвэрлүүлж хийсэн хөрөнгийн бүртгэлээс СТОУС-ын дагуу тайлагнан цаашид үлдсэн 1,025.5 сая төгрөг. Өргөтгөлийн зээлийн төлбөр 45.9 сая амдоллар буюу 163,525.4 сая төгрөг байна.

Өглөг	Оны эхэнд	Зорилтот түвшин	Тайлангийн эцэст	Зөрүү оны эхнээс	Зөрүү зорилтоос	хувь
Богино хугацаат өр төлбөр	15,532.5	11,300.5	66,546.6	51,014.2	55,246.1	28.8%
УОО ДЭХ	59.2	-	28.1	(31.1)	28.1	0.0%
Нүүрсний өглөг	4,035.2	-	4,217.8	182.6	4,217.8	1.8%
Татварын өглөг	193.0	-	166.0	(27.0)	166.0	0.1%
Зээл	2,000.0	-	41,163.0	39,163.0	41,163.0	17.8%
Зээлийн хүүгийн өглөг	-	-	4,431.5	4,431.5	4,431.5	1.9%
Бусад БХӨТ	9,245.0	11,300.5	16,540.2	7,295.1	5,239.7	7.2%
Урт хугацаат өр төлбөр	807.7	176,700.0	164,550.9	163,743.2	(12,149.1)	71.2%
Бүгд	16,340.2	188,000.5	231,097.5	214,757.3	43,097.0	100.0%



■ Оны эхэнд ■ Зорилтот түвшин ▬ Тайлангийн эцэст

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, орлого үр дүн

Тайлант хугацаанд 404.9 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулан, 345.5 сая кВтц цахилгаан түгээж, түгээлтийн төлөвлөгөө 2.9 сая.кВт-аар тасарч буюу 99.2%-иар биелүүллээ. Энэ онд 651.8 мян.Гкал дулаан түгээж, түгээлтийн төлөвлөгөөг 0.1 мян.Гкал-аар илүү буюу 100.0%-иар биелүүлсэн. Нийт боловсруулсан ЦЭХ-ний 14.04%-ийг дотоод хэрэгцээндээ хэрэглэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 14.66%-тай гарч, 0.62 пунктээр өсөв.


д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны тодотгосон төлөв	2025 оны гүйцэтгэл	зөрүү төлөв-өөс	зөрүү өнгөрсөн оноос
1	ЦЭХ боловсруулалт	сая.кВт.ц	432.1	405.3	404.9	-0.4	-27.3
2	ДЭХ боловсруулалт	мян.Гкал	699.6	703.2	703.8	0.6	4.2
3	ДХЦЭХ	сая.кВт	58.7	56.9	59.3	2.4	0.6
5	ДХЦЭХ хувь	%	13.59%	14.04%	14.66%	0.62%	1.06%
4	ЦЭХ түгээлт	сая.кВт.ц	373.4	348.4	345.5	-2.9	-27.9
6	ДЭХ түгээлт	мян.Гкал	647.0	651.7	651.8	0.1	4.8

7	ЦЭХ-ний зардал	сая төг	57,980.6	85,675.6	79,720.2	(5,955.4)	21,739.6
8	ЦЭХ-ний орлого	сая төг	68,617.3	82,017.7	81,683.5	(334.2)	13,066.2
9	ЦЭХ-ний ашиг алдагдал	сая төг	10,636.7	(3,657.9)	1,963.2	5,621.2	(8,673.5)
10	ДЭХ-ний зардал	сая төг	31,303.1	25,535.2	24,766.4	(768.7)	(6,536.7)
11	ДЭХ-ний орлого	сая төг	15,074.9	15,141.4	15,810.5	669.1	735.6
12	ДЭХ-ний ашиг алдагдал	сая төг	(16,228.1)	(10,393.7)	(8,955.9)	1,437.9	7,272.3
13	Нийт орлого	сая төг	83,692.2	97,159.1	97,494.0	334.9	13,801.8
14	Нийт зардал	сая төг	89,283.7	111,210.8	104,486.6	(6,724.1)	15,203.0
15	Үүнээс: АНЗ	сая төг	2,000.8	2,459.8	2,547.1	87.2	546.3
16	үйлд ашиг алдагдал	сая төг	(5,591.4)	(14,051.7)	(6,992.6)	7,059.0	(1,401.2)
17	Үйлдв. бус орлого	сая төг	6,947.9	191.8	1,382.2	1,190.4	(5,565.7)
18	Үйлдв. Бус зардал	сая төг	1,043.0	479.5	333.7	(145.8)	(709.4)
19	үйлд бус ашиг алдагдал	сая төг	5,904.9	(287.7)	1,048.5	1,336.2	(4,856.4)
20	Ашиг алдагдал	сая төг	266.4	(14,339.4)	(5,944.1)	8,395.3	(6,210.5)
21	Татварын зардал ТХХ	сая төг	47.0	-	-	-	(47.0)
22	Татварын дараахь ашиг	сая төг	266.4	(14,339.4)	(5,944.1)	8,395.3	(6,210.6)
23	ЦЭХ-ний өртөг	төг/кВт.ц	155.28	245.91	230.71	(15.19)	75.43
24	ЦЭХ-ний үнэ	төг/кВт.ц	183.77	235.41	236.39	0.99	52.63
25	ДЭХ-ний өртөг	төг/Гкал	48,381.73	39,183.07	37,996.89	(1,186.18)	(10,384.84)
26	ДЭХ-ний үнэ	төг/Гкал	23,299.68	23,234.12	24,256.70	1,022.58	957.03
27	1Квт ЦЭХ-нээс олсон ашиг	төг/кВт.ц	28.49	(10.50)	5.68	16.18	(22.80)
28	1Гкал ДЭХ-нээс алдагдал	төг/Гкал	(25,082.06)	(15,948.95)	(13,740.19)	2,208.76	11,341.87


Нэг кВт ЦЭХ-ийг 230.71 төгрөгөөр үйлдвэрлэж, ДҮТ ХХК-нд дундажаар 236.13 төгрөгөөр, өөрийн борлуулалтаар 265 төгрөгөөр нийлүүлж, дундажаар нэг кВт ЦЭХ-ийг 236.39 төгрөгөөр борлуулсан. Нэг Гкал ДЭХ-ийг 37,996.89 төгрөгөөр үйлдвэрлэж, 24,256.70 төгрөгөөр орон нутгийн хэрэглэгчдэд тус тус борлуулжээ. Төлөвлөгөөнөөс нэгж өртгийг нэг кВт ЦЭХ-нд 15.19 төгрөгөөр, нэг Гкал ДЭХ-нд 1,186.18 төгрөгөөр тус тус буурч ажилласан байна. 1 кВт ЦЭХ-ээс 5.68 төгрөгийн ашигтай, 1 Гкал ДЭХ-ээс 13,740.19 төгрөгийн алдагдалтай үйлдвэрлэл явуулжээ.

Тайлант хугацаанд төлөвлөгөөгөөр татварын өмнө 14,339.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас 5,944.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, тайлант үеийн батлагдсан төлөвлөгөөт алдагдлыг 8,395.3 сая төгрөгөөр бууруулан ажиллалаа. Үүнд: Үйл ажиллагааны орлого 334.9 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал 6,724.1 сая төгрөгөөр хэмнэн, үйл ажиллагааны бус ашгийг 1,336.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн ажилласан байна.

ЦЭХ, ДЭХ-ний орлогын хувийн жин
/сая.төг /



ЦЭХ, ДЭХ-ний зардлын хувийн жин
/сая.төг/



Борлуулалтын орлого. Тайлант хугацаанд нийт 97,494.0 сая төгрөгийн эрчим хүчний борлуулалт хийсэн. Нийт орлогын 83.8%-ийг ЦЭХ-ний орлого, 16.2%-ийг ДЭХ-ний орлого эзэлж байна.

ЦЭХ-ний борлуулалт: 81,683.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн ба ДҮТ ХХК-д горимоор тайлант хугацаанд 342.9 сая кВт ЦЭХ нийлүүлж 80,957.1 сая төгрөгийн ЦЭХ-ний борлуулалт хийсэн ба 2.7 сая кВт

буюу 710.9 сая төгрөг нь өөрийн хэрэгцээний цахилгаан байна. 15.5 сая төгрөгийн СПОТ-ын орлого орсон. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны тодотгосон төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	өөрчлөлт		Үнийн зөрүүгээс	Биетийн зөрүүгээс
						төлөв-өөс	өмнөх оны мөн үеэс		
1	ЦЭХ-ний нийт түгээлт	сая.кВт	373.393	348.406	345.538	(2.9)	(27.9)		
	Дундаж үнэ	төг/кВтц	183.77	235.41	236.39	0.99	52.63		
2	ДҮТ ХХК-д түгээсэн	сая.кВт	370.520	345.522	342.856	(2.7)	(27.7)		
	Энергийн тариф	төг/кВтц	98.08	108.55	108.53	(0.02)	10.46		
	Энергийн тарифаар	сая төг	36,340.0	37,508.0	37,211.6	(296.4)	871.6	(7.0)	(289.4)
	Чадлын тарифаар	сая төг	31,640.2	43,745.5	43,745.5	-	12,105.3	-	
	Нийт орлого ДҮТ-д түгээсэн	сая төг	67,980.2	81,253.5	80,957.1	(296.4)	12,976.9	(7.0)	(289.4)
3	Өөрийн борлуулалт	сая төг	637.1	764.2	726.4	(37.8)	89.3		(37.8)
	НИЙТ ОРЛОГО	сая.төг	68,617.3	82,017.7	81,683.5	(334.2)	13,066.2	(7.0)	(327.3)

ЦЭХ-ний орлого төлөвлөснөөс 344.2 сая төгрөгөөр тасарсан. ДҮТ ХХК-д нийлүүлсэн цахилгааныг ЭХЗХ-ны 2025 оны 57 тоот тогтоолоор батлагдсан үнэ тарифыг мөрдсөн. ДҮТ ХХК-д нийлүүлсэн цахилгааны биетээс 289.4 сая төгрөг буурч, энергийн тарифын өөрчлөлтөөс 7.0 сая төгрөг буурч, ашиглалтын цахилгаан, цахилгаан түгээлтийн алдагдал, үйлдвэрлэлийн бус цахилгааны биетийн бууралтаас 53.3 сая төгрөг буурсан. СПОТ-ын орлого 15.5 сая төгрөг.

ДЭХ-ний борлуулалт: 2025 онд төлөвлөгөөгөөр 15,141.4 сая төгрөгийн борлуулалт хийхээс гүйцэтгэлээр 15,810.5 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын орлогын төлөвлөгөөг 669.1 сая төгрөгөөр давуулж, 104.4%-иар биелүүлж ажиллав. Төлөвлөснөөс усаар түгээсэн ДЭХ-ний орлого 604.5 сая төгрөгөөр, уураар түгээсэн ДЭХ-ний орлого 68.2 сая төгрөгөөр давж биелсэн.

№	Нэр төрөл	Хэмж. Нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Өөрчлөлт	
						Төлөвлө-гөөнөөс	өмнөх оны мөн үе-с
1	ДЭХ-ний боловсруулалт	мян.Гкал	699.590	651.689	651.801	0.112	-47.789
	Нэгж үнэ	төгрөг	21,548.25	23,234.10	24,256.64	1,028.15	2,714.0
	Бүгд үнэ	сая.төг	15,074.9	15,141.4	15,810.5	672.7	739.2

Нийт ДЭХ борлуулалтын орлогын 255.8 сая төгрөг буюу 1.6%-ийг уураар, 15,554.7 сая төгрөг буюу 98.4%-ийг усаар тус тус хийв.

ДУЛААНЫ ОРЛОГЫН БҮТЦИЙГ БҮЛГЭЭР ХАРУУЛБАЛ:





№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйц	2024 оны гүйц	2025 он			Зөрүү мөн үеэс		
					Төлөв	Гүйцэтгэл	Зөрүү	нийт	биетээс	Үнийн зөрүүгээс
I	Нийт орлого	сая төг	12,447.1	15,074.9	15,141.4	15,810.5	669.1	735.6	735.6	
	Уурын орлого	сая төг	341.6	230.4	187.6	255.8	68.2	25.4	(111.2)	-
		%	2.74	1.53	1.24	1.62	0.38	0.09		
	Усны орлого	сая төг	12,105.5	14,844.5	14,953.7	15,554.7	601.0	710.2	710.2	
		%	97.26	98.47	98.76	98.38	(0.38)	(0.09)		-

Өртөг зардал, үр ашгийн талаар.

Тайлант хугацаанд нийт 104,820.3 сая төгрөгийн зардал зарцуулсан бөгөөд үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 104,486.6 сая төгрөгийг зарцуулжээ. 2025 онд үйл ажиллагааны 24 нэр төрлийн зардлаас 15 нэр төрлийн зардлыг 7,492.5 сая төгрөгөөр хэмнэж, 9 нэр төрлийн зардал (туслах материал, шатахуун, тээвэр, сэлбэг, цахилгаан, гал, борлуулалтын шимтгэл, АНЗ) 768.2 сая төгрөгөөр хэтэрсэн.

Нийт үндсэн үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөтэй харьцуулж харуулвал:

**Нийт зардлын гүйцэтгэлийг эзэлж байгаа хувиар харуулбал:****Нийт зардалд:**

- Түлшний зардал 40,584.4 сая төгрөг буюу 38.8%
- Цалин, НДШ 29,401.0 сая төгрөг буюу 28.1%
- Элэгдэл 9,874.7 сая төгрөг буюу 9.5%
- Бусад зардал 6,963.2 сая төгрөг буюу 6.7%
- Борл.лтын шимтгэл 5,270.4 сая төгрөг буюу 5.0%
- Ус 5,081.6 сая төгрөг буюу 4.9%

- АНЗ 2,547.1 сая төгрөг буюу 2.4%
- Ерөнхий ба Удирдл. зардал 2,253.0 сая төг буюу 2.2%
- Сэлбэг урсгал зардал 1,666.1 сая төгрөг буюу 1.6%
- Шатахуун 845.3 сая төгрөг буюу 0.8%-г тус тус эзэлж байна.

Зардлын гүйцэтгэл:

д/д	зардлын төрөл	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны тод төлөв	2025 оны гүйц	Зөрүү төлөв-өөс	Зөрүү өнгөрсөн оноос
1	Түлшний зардал	сая төг	36,793.11	42,354.76	40,584.38	(1,770.4)	3,791.3
2	Туслах материал	сая төг	256.43	151.94	187.88	35.9	(68.6)
3	Шатахуун	сая төг	992.70	836.94	845.26	8.3	(147.4)
4	Тээврийн зардал	сая төг	-	-	1.60	1.6	1.6
5	Сэлбэг, урсгал зардал	сая төг	2,075.95	1,458.69	1,666.07	207.4	(409.9)
6	Цалин, НДШ	сая төг	25,333.28	29,387.87	29,401.02	13.1	4,067.7
7	Цахилгаан	сая төг	169.86	94.84	244.50	149.7	74.6
8	Ус	сая төг	5,874.16	5,646.03	5,081.57	(564.5)	(792.6)
9	Томилолт	сая төг	57.65	44.90	39.64	(5.3)	(18.0)
10	Бичиг хэрэг	сая төг	38.57	46.40	40.88	(5.5)	2.3
11	Холбоо	сая төг	26.87	28.40	27.93	(0.5)	1.1
12	Хөд.хамгаалал	сая төг	775.37	782.96	655.86	(127.1)	(119.5)
13	Гал команд	сая төг	39.50	41.60	49.02	7.4	9.5
14	Харуул хамгаалалт	сая төг	119.67	60.00	40.69	(19.3)	(79.0)
15	Элэгдэл	сая төг	6,613.42	10,490.94	9,874.73	(616.2)	3,261.3
16	Гадны ажил үйлчилгээ	сая төг	415.75	323.00	234.25	(88.8)	(181.5)
17	Зээлийн хүү	сая төг	617.10	8,147.90	4,580.96	(3,566.9)	3,963.9
18	Ерөнхий ба удирдлага	сая төг	1,790.1	2,815.3	2,253.0	(562.4)	462.9
	Захиргаа	сая төг	505.97	1,171.26	712.88	(458.4)	206.9
	ТУЗ	сая төг	170.15	178.56	171.68	(6.9)	1.5
	Газрын төлбөр	сая төг	202.17	202.31	202.17	(0.1)	(0.0)
	Автын татвар, даатгал	сая төг	12.57	15.84	15.21	(0.6)	2.6
	Аудит	сая төг	32.24	39.24	39.24	-	7.0
	Эрчис Монгол	сая төг	-	233.50	234.05	0.6	234.1
	ЭХЗХ	сая төг	301.90	375.00	375.00	0.0	73.1
	Үл хөдлөх хөрөнгө	сая төг	336.64	393.95	293.79	(100.2)	(42.9)
	Ус ашигл.төлбөр	сая төг	200.37	176.96	181.76	4.8	(18.6)
	Агаарын бохирдлын төлбөр	сая төг	28.05	28.73	27.18	(1.5)	-(0.9)
19	Зар сурталчилгаа	сая төг	75.28	197.30	90.91	(106.4)	15.6
20	Цах. түгээлт.алдагд	сая төг	543.41	658.22	620.04	(38.2)	76.6
21	сургалт	сая төг	165.73	79.70	73.18	(6.5)	(92.5)
22	Ашиглалтын цахилгаан	сая төг	64.01	90.31	75.82	(14.5)	11.8
23	Борлуулалтын шимтгэл	сая төг	4,445.02	5,148.24	5,270.42	122.2	825.4
	Бүгд	сая төг	87,282.9	108,886.3	101,939.6	(6,946.7)	14,656.7
24	АНЗ: Үүнээс	сая төг	2,000.8	2,324.4	2,547.1	222.6	546.3
	Тэтгэвэр тэтгэмж	сая төг	1,122.51	1,485.45	1,794.18	308.7	671.7
	Түлшний хөнгөлөлт	сая төг	52.41	50.95	49.96	(1.0)	(2.4)
	Хоолны хөнгөлөлт, НДШ	сая төг	657.47	783.06	702.93	(80.1)	45.5
	СОТАХ	сая төг	74.53	-	-	-	(74.5)
	Унааны хөнгөлөлт	сая төг	2.79	4.99	-	(5.0)	(2.8)
	Шагнал	сая төг	91.08	-	-	-	(91.1)
	Нийт зардал Бүгд	сая төг	89,283.7	111,210.8	104,486.6	(6,724.1)	15,203.0

Түлшний зардал:

	Төрөл	Хэмжих нэгж	2025 он				
			Шарын гол	Багануур	Бүгд нүүрс	Мазут	Бүгд
Тодотгосон төлөвлөгөө	Бодит хэрэглээ	мян.тн	529.22	20.09	549.31	150.40	
	Жишмэлээр	мян.тн	253.85	9.73	263.58	206.26	469.85
	Илчлэг	Ккал/кг	3357.66	3391.58	3358.90	9600.00	
	1 тн түлшний үнэ	төг	75,459.44	80,275.50	75,635.59	5,000.00	
	Бүгд үнэ	сая.төг	39,934.8	1,612.9	41,547.7	752.0	42,354.8
Гүйцэтгэл			Шарын гол	Багануур	Бүгд нүүрс	Мазут	Бүгд
	Бодит хэрэглээ	мян.тн	512.54	21.29	533.83	171.50	
	Жишмэлээр	мян.тн	250.85	10.58	261.44	235.20	496.64
	Илчлэг	Ккал/кг	3426.04	3479.73	3428.18	9600.00	
	1 тн түлшний үнэ	төг	74,918.32	82,573.99	75,223.63	2,260.86	
	Бүгд үнэ	сая.төг	38,398.5	1,757.9	40,156.4	387.7	40,584.9
Зөрүү			Шарын гол	Багануур	Бүгд нүүрс	Мазут	Бүгд
	биетийн зөрүү	мян.тн	-16.68	1.20	-15.49	21.10	0.00
	биетийн зөрүү	сая.төг	(1,260.1)	90.6	(1,169.5)	105.5	(1,064.0)
	1 тн түлшний үнэ	төг	(541.12)	2,298.50	(411.97)	(2,739.14)	
	Үнийн зөрүүгээс	сая.төг	(273.10)	54.34	(218.76)	(469.76)	(688.53)
	Бүгд үнэ	сая.төг	(1,536.2)	145.0	(1,391.2)	(367.7)	(1,769.9)

Түлшний зардал нийт 1,769.9 сая төгрөгөөр хэмнэсэн. Үүнд:

- Нүүрс 1,391.2 сая төгрөгөөр хэмнэсэн.
- Төлөвлөсөнтэй харьцуулахад биетээр 15.5 мян.тн нүүрс бага зарцуулсан. Үүнд:
 - Дулааны илүү түгээлтээс 0.1 мян.тн хэтэрсэн.
 - Дулаан гаргах чадварын зөрүүгээс 11.1 мян.тн
 - Цахилгааны дутуу түгээлтээс 2.4 мян.тн
 - Түлшний хувийн зарцуулалтын бууралтаас 2.1 мян.тн хэмнэсэн.
- ЭХЗХорооны 2024 оны 694, 696, 2025 оны 167, 169 тоот тогтоолуудын мөрдөж ажилласан. 2025 оны 4 сарын 01-ны өдрөөс сард эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй Багануурын нүүрсний тооцоог 1 тн тутамд 54,091 төгрөгөөс өөрчлөн 51,386 төгрөгөөр, Шарын голын нүүрсний тооцоог 65,315 төгрөгөөс өөрчлөн 62,049 төгрөгөөр болгон бууруулсан.

Шарын голын нүүрс биетээс 1,260.1 сая төгрөг, үнийн зөрүүгээс 276.1 сая төгрөг хэмнэсэн. Багануурын нүүрс биетээс 90.6 сая төгрөг, үнийн зөрүүгээс 54.3 сая төгрөг хэтэрсэн.

- Мазут нийт 150.4 тонн төлөвлөснөөс гүйцэтгэлээр 171.5 тн-ыг зарцуулж, 21.1 тн буюу 105.5 сая төгрөг, үнийн зөрүүгээс 469.8 сая төгрөг, мазутгүй галлагааны урамшууллаас 14.4 сая төгрөг хэмнэсэн.

Туслах материалын зардал: 151.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 187.9 сая төг зарцуулсан. Тайлант хугацаанд:-

- Давсны хүчил 18.7 тн буюу 69.1 сая төгрөг
- Натрийн шүлт 10.7 тн буюу 46.7 сая төгрөг
- Цэвэрлэгээний бодис 750 кг буюу 16.1 сая төгрөг
- Анионит АВ-17-8 1 тн буюу 10.5 сая төгрөг
- Аммиак 2.3 тн буюу 13.1 сая төгрөг
- Фосфат 775 кг буюу 4.8 сая төгрөг
- Бусад бодисыг ашигласан байна.


Орон тоо, цалин хөлс: Тайлант хугацаанд манай компани 1 алба, 5 хэлтэс, 8 цехийн зохион байгуулалттай, 471 ажилчидтай үйл ажиллагаа явуулж, 97,494.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулснаас нэг ажилтны дундаж бүтээмж 207.0 сая төгрөг, үүнээс үндсэн үйлдвэрлэлийн нэг ажилтны

хөдөлмөрийн бүтээмж 284.2 сая.төг болж, өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн ажилтны бүтээмжээс 0.3%-иар буюу 37.3 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Нийт ажилчдаас удирдах ажилтан 4, ИТА албан хаагч 124, ажилчид ба бага тушаалын ажилтан 343, өмнөх оны мөн үеэс 5 хүний орон тооноос нэмэгдсэн. Ажилчдын дундаж цалин 4,032,092 төгрөг буюу өмнөх оны мөн үеийнхээс 400,835 төгрөгөөр өссөн.

Нийт ажилчдын 24.4% нь 15-аас дээш жил, 25.2% нь 7-15 жил, 34.1% нь 2-6 хүртэлх жил, 16.3% нь 0-2 жил ажиллаж байна. Удаан жилийн нэмэгдлийг нийт ажилчдын 83.8% буюу 395 хүн авч байгаагийн 40.1% нь 35-40%-ийн нэмэгдэлд хүрсэн бөгөөд хэвийн нөхцөлд 69 хүн, хэвийн бус нөхцөлд 402 хүн ажиллаж байна.

Удаан жил ажилласны нэмэгдлийн хувь, тоо





Тайлант хугацаанд цалингийн зардалд төлөвлөгөөгөөр 26,330.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 26,229.2 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэлийн хувь 99.6% буюу 101.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан.

Цалингийн зардлын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,620.9 сая төгрөгөөр буюу 16%-иар өссөн. Ажилчдын үндсэн цалинг 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс 10%-иар нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд сахилгын арга хэмжээ 18 хүн дээр тооцогдож, үндсэн цалин, удаан жилийн нэмэгдэл, сарын үр дүнг 23.4 сая төгрөгөөр бууруулсан. Бүтэц орон тооны хувьд 473 хүнтэй ажиллахаас 2 менежерийн орон тоо хасагдаж, цалингийн зардлаас 121.3 сая төгрөг хэмнэгдсэн. Өндөр настны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн 20 хүн ажлаас гарсан. Эдгээр ажилчид нь олон жил ажилласан, өндөр зэрэгтэй ажилчид бөгөөд цалингийн зардал дээр удаан жилийн нэмэгдэл, цаг зэргийн тарифын зөрүүгээр 60.7 сая төгрөг тус тус хэмнэгдсэн.

Нийт цалингийн сангийн гүйцэтгэлийг ажилчдын категори тус бүрээр урьд оны мөн үе болон тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулан харуулбал:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үеийн гүйц	Тайлант оны		Өөрчлөлт	
				Тодот төлөв	Гүйц	Өнгөрсөн оноос	Төлөв-өөс
1	Ажиллагсдын тоо	тоо	465	473	471	6	2
	Цалингийн сан	сая.төг	20,262.4	22,794.2	22,789.4	2,527.0	(4.8)
	Үндсэн	сая.төг	9,484.7	10,085.2	10,022.2	537.5	(63.0)
	Нэмэгдэл	сая.төг	6,208.2	7,466.4	7,842.6	1,634.4	376.2
	Шагнал	сая.төг	4,569.5	5,242.6	4,924.5	355.0	(318.1)
	Дундаж цалин /ЖҮД-гүй/	төгрөг	3,631,257	4,015,890	4,032,093	400,836	16,203
а	Үүнээс: Удирдлага	тоо	3	6	4	0	-2
	Цалингийн сан	сая.төг	339.9	589.4	521.6	181.7	(67.8)
	Үндсэн	сая.төг	159.4	297.4	220.1	60.7	(77.2)

	Нэмэгдэл	сая.төг	108.3	143.3	196.3	88.1	53.0
	Шагнал	сая.төг	72.2	148.7	105.1	33.0	(43.6)
	Дундаж цалин	төгрөг	9,440,927	8,186,200	10,866,643	1,425,716	2,680,443
б	Ажилчид	тоо	339	343	343	4	0
	Цалингийн сан	сая.төг	13,231.3	15,072.6	15,101.0	1,869.7	28.3
	Үндсэн	сая.төг	6,226.3	6,405.4	6,403.1	176.8	(2.2)
	Нэмэгдэл	сая.төг	3,989.2	5,264.6	5,543.9	1,554.7	279.3
	Шагнал	сая.төг	3,015.8	3,402.7	3,153.9	138.2	(248.7)
	Дундаж цалин	төгрөг	3,252,524	3,661,965	3,668,853	416,329	6,888
в	ИТА, АХ	тоо	123	124	124	1	0
	Цалингийн сан	сая.төг	6,691.3	7,132.1	7,166.8	475.5	34.7
	Үндсэн	сая.төг	3,098.9	3,382.5	3,398.9	300.0	16.5
	Нэмэгдэл	сая.төг	2,110.7	2,058.4	2,102.4	(8.4)	43.9
	Шагнал	сая.төг	1,481.6	1,691.2	1,665.5	183.9	(25.8)
	Дундаж цалин	төгрөг	4,533,384	4,793,101	4,816,391	283,007	23,290
г	Жилийн үр дүн	сая.төг	2,345.8	3,536.4	3,439.8	1,094.0	(96.6)
	Удирдлага	сая.төг	34.8	74.9	74.3	39.5	(0.6)
	Ажилчид	сая.төг	1,535.7	2,299.2	2,213.2	677.5	(86.0)
	ИТА, АХ	сая.төг	775.3	1,162.3	1,152.3	377.0	(10.0)
Нийт цалингийн сан		сая.төг	22,608.3	26,330.6	26,229.2	3,621.0	(101.4)
2	ЖҮД-тэй дундаж цалин	төгрөг	4,051,660	4,638,939	4,640,696	589,036	1,757



Сарын үр дүнгийн нэмэгдэл цалинд 5,053.3 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,801.7 сая төгрөг зарцуулж, 251.6 сая төгрөг хэмнэсэн. Үр дүнгийн нэмэгдэл цалинг 50%-иар олгохоор төлөвлөгөөнд тусгагдснаас дундажаар 45.2%-иар олгосон. Олгосон нэмэгдэл цалингийн дундаж хувь өмнөх оны мөн үеийнхээс 3%-иар буурсан. Тайлант хугацаанд сарын ажлын үр дүнгээр нэмэгдэл цалин олгох журмын дагуу ажлын хариуцлага алдсан, технологийн болон сахилгын зөрчил, төлбөрийн акт, ажлын цаг ашиглалт зэрэг үзүүлэлтүүдээр нийт давхардсан тоогоор 257 хүн буюу 51.4 сая төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл цалинг хасч тооцсон.

Цалингийн зардлын төрөл тус бүрийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулж үзвэл илүү цагийн нэмэгдэл 0.3%-иар, амралтын мөнгө 0.9%-иар, жилийн үр дүнгийн нэмэгдэл 3.1%-иар, бусад нэмэгдэл 0.4%-иар, удаан жилийн нэмэгдэл 0.3%-иар өссөн бол үр чадварын нэмэгдэл 0.1%-иар, шөнө цагийн нэмэгдэл 0.6%-иар, үндсэн цалин 1.8%, сарын үр дүнгийн нэмэгдэл цалин 1.7%-иар, зардалд эзлэх хувийн жин нь буурсан.

№	Үзүүлэлт	өмнөх оны мөн үе	төлөвлөгөө	Гүйцэтгэл	сая.төг			
					Биелэлтийн		Өмнөх оноос	
					хувь	зөрүү	хувь	зөрүү
1	Цагаар олгосон хөлс	9,370.50	10,345.2	10,276.9	99.3	(68)	1.10	906.4
2	Сарын үр дүнгийн нэмэгдэл	4,569.50	5,053.3	4,801.7	95.0	(252)	1.05	232.2
3	Илүү цагийн нэмэгдэл	1,046.40	1,141.6	1,272.6	111.5	131	1.22	226.2
4	Удаан жилийн нэмэгдэл	2,318.70	2,704.3	2,691.3	99.5	(13)	1.16	372.6
5	Шөнийн нэмэгдэл	815.8	919.0	892.4	97.1	(27)	1.09	76.6
6	Хэвийн бус нөхцлийн нэмэгдэл	73.6	274.2	271.9	99.1	(2)	3.69	198.3
7	Хослон, хавсран ажилласан бусад нэмэгдэл	165.7	21.1	20.3	96.2	(1)	0.12	-145.4
8	Үр чадвар, бригадын даргын нэмэгдэл	1,788.00	198.6	236.9	119.3	38	0.13	-1551.1
9	Амралтын цалин	114.2	2,337.0	2,325.5	99.5	(11)	20.36	2211.3
10	Жилийн үр дүн	2,345.80	3,536.4	3,439.8		(97)		1094.0
	Бүгд	22,608.30	26,530.6	26,229.2	98.9	(301)	1.16	3620.9

Тайлант хугацаанд нийт 103,877 х/өдөр 831,016 х/цаг ажиллахаас 100,605 х/өдөр 804,838 х/цаг ажиллаж, ажлын цаг ашиглалтын хувь 96.8%-тай байна. Ажиллаагүй цаг буюу ажлын цагийн гарздал 26,178 х/цаг байгаагаас захиргааны чөлөө 5,848 х/цаг, тасалсан 856 х/цаг, өвчтэй 2,434 хүн өдөр буюу 19,474 х/цаг байлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчлөл 5,362 х/цагаар өсч, эмнэлэг сувилалд эмчлүүлэх ердийн өвчний өвчлөлийн хугацаа өссөн байна. Захиргааны чөлөөтэй цаг 5,482 х/цагаар, ажил таслалт 200 х/цагаар тус тус буурсан.

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Биелэлт	
					Хувь	өмнөх оныхоос
1	Нийт бүтээгдэхүүн / сая.төг-өөр/	83,692.2	97,159.0	97,494.0	100.3	13802
2	Ажиллагсдын тоо	465	473	471	99.6	6
3	Үүнээс: ажилчид	339	343	343	100.0	4
4	Ажилласан хүн өдөр	99,383	103,877	100,605	96.9	1222
5	Ажилласан нийт хүн цаг	795,064	831,016	804,838	96.8	9774
6	Нийт ажиллагсдад эзлэх ажилчдын хувийн жин	0.7	0.7	0.7	100.4	0
7	Нэг ажилчны ажилласан дундаж өдрийн тоо	213.7	219.6	213.6	97.3	-0.1
8	Ажлын өдрийн үргэлжлэх хугацаа	8.0	8.0	8.0	100.0	0
9	Нэг ажилтны дундаж бүтээмж /мян.төг-өөр/	179,983.2	205,410.1	206,993.6	100.8	27010
10	Үйлдвэрийн 1 ажилчны хөдөлмөрийн бүтээмж	246,879.6	283,262.4	284,239.1	100.3	37359
11	Өдрийн бүтээмж /мян.төг-өөр/	842.1	935.3	969.1	103.6	127
12	1 цагт ноогдох хөдөлмөрийн бүтээмж /мян.төг/	105.3	116.9	121.1	103.6	16

Усны зардал: Усны зардал 564.5 сая төгрөг хэмнэж, ус ашиглалтын төлбөр 4.8 сая төгрөг хэтэрсэн.

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	2024 оны гүйц	2025 оны тодотгос он төлөв	2025 оны гүйц	Өмнөх оноос зөрүү	Төлөв лөснөөс зөрүү	Үнийн зөрүү гэс	Биетийн зөрүүгээс
1	Технологийн ус	мян.м3	2146.23	2048.78	1825.19	-321.04	-223.6		-223.6
	Нэгж үнэ	төг/м3	2,610	2,610	2,610	0.00	0	-	2,610
	Бүгд үнэ	сая.төг	5,601.7	5,347.3	4,763.8	(837.9)	(583.6)	-	(583.6)
	Суурь хураамж	сая.төг	3.4	3.4	3.4	-	-	-	
	Эрдэнэт үйлдвэрт төлөх төлбөр	сая.төг	5,605.1	5,350.7	4,767.2	(837.9)	(583.6)	-	(583.6)
2	Цэвэр ус	мян.м3	59.60	65.23	69.74	10.15	4.5		4.5
	Нэгж үнэ	төг/м3	2,610	2,610	2,610	0.00	0		2,610
	Бүгд үнэ	сая.төг	155.5	170.3	182.0	26.5	11.8	-	11.8
	Суурь хураамж	сая.төг	1.1	1.1	1.1	(0.0)	(0.0)		(0.0)
	Бохир ус	мян.м3	59.51	65.60	69.47	9.97	3.9		3.9
	Нэгж үнэ	төг/м3	1,890	1,890	1,890	0.00	0	-	1,890
	Бүгд үнэ	сая.төг	112.5	124.0	131.3	18.8	7.3	-	7.3
	Эрдэнэт ус ОНӨХК-д төлөх төлбөр	сая.төг	269.1	295.3	314.4	45.3	19.1	-	19.1
	УСНЫ ЗАРДАЛ	сая.төг	5,874.2	5,646.0	5,081.6	(792.6)	(564.5)	-	(564.5)

Технологийн хэрэгцээнд 2025 онд 2048.8 мян.тн ус хэрэглэхээр төлөвлөж, 1825.2 мян.тн ус хэрэглэж 223.6 мян.тн-н хэмнэлттэй гарч төлөвлөсөн зардал 792.6 сая төгрөгөөр хэмнэсэн. Технологийн ус хэмнэх техник зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласнаас хэмнэсэн. Ахуйн хэрэгцээнд 65.2 мян.тн цэвэр, бохир ус хэрэглэхээр төлөвлөснөөс 69.7 мян.тн цэвэр ус ашиглан 69.5 мян.тн бохир усны тооцоо хийсэн. Ахуйн усны хэрэглээний хэтрэлтээс 4.3 мян.тн буюу 16.8 сая төгрөг хэтэрсэн.

Нэр төрөл	Хэмжих нэгж	2024 оны гүйц	2025 оны тодотгосон төлөв	2025 оны гүйц	Өмнөх оноос зөрүү	Төлөв-өөс зөрүү	Үнийн зөрүүгээс	Биетийн зөрүүгээс
Гүний худгаас	мян.м3	551.57	476.57	351.92	-199.65	-124.7	351.9	-124.7
Нэгж үнэ	төг/м3	74.18	74.18	74.18	0.00	0.0	0.0	74.18
Бүгд үнэ	сая.төг	40.9	35.4	26.1	(14.8)	(9.2)	-	(9.2)
Эрдэнэт голоос	мян.м3	336.24	295.92	261.36	-74.88	-34.6	261.4	-34.6
Нэгж үнэ	төг/м3	55.66	55.66	55.66	0.00	0.0	0.0	55.7
Бүгд үнэ	сая.төг	18.7	16.5	14.5	(4.2)	(1.9)	-	(1.9)
Техникийн ус	мян.м3	2146.23	2048.78	1825.19	-321.04	-223.6	1825.2	-223.6
Нэгж үнэ	төг/м3	61.08	61.08	61.08	0.00	0.0	0.0	61.1
Бүгд үнэ	сая.төг	131.1	125.1	111.5	(19.6)	(13.7)	-	(13.7)
Ус бохирдуулсны төлбөр	сая.төг	9.6	-	29.6	20.0	29.6		
УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	сая.төг	200.4	177.0	181.8	(18.6)	4.8	-	(24.8)

Гүний худгуудаас 2025 онд 476.6 мян.тн ус хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 351.9 мян.тн усыг авч хэрэглэж, 199.7 мян.тн усыг хэмнэсэн. Гүний худгуудад гэмтэл гарч зогссон, НОВ-н далан засварлах, техникийн усны бак хатуурах зэрэгт бэлтгэлд зогсоосноос хамаарсан. Эрдэнэт голоос 295.9 мян.тн ус хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 261.3 мян.тн усыг авч хэрэглэж, 34.6 мян.тн усыг хэмнэсэн

Хөдөлмөр хамгаалал: 2025 онд 782.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 655.9 сая төгрөг зарцуулан, 127.1 сая төгрөг хэмнэсэн. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, аливаа аваари, ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ажлын байран дээрхи ХАБЭА-н тухай хууль дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм журмын мөрдөлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөлт, нарядын

системийн мөрдөлт, цех хэсгүүдэд нарыаар орж байгаа ажил болон ажлын байрны эрсдлийн түвшинг хэрхэн бууруулж ажил гүйцэтгэж байгаад болон цехүүдийн ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавьж эргэлт шалтгалт хийж ажиллав.

Ерөнхий ба Удирдлагын зардал: Нийт 562.4 сая төгрөгөөр хэмнэсэн. Захиргааны зардал 458.4 сая төг, ТУЗ-н зардал 6.9 сая төгрөг, ерөнхий зардал 97.1 сая төгрөг хэмнэсэн. Гүйцэтгэх удирдлагын зардлаас цалингийн зардал цалингийн санд хянагдсан тул зөрүү дүнг томилолтын зардалд хуваарилсан. Томилолтын зардал бодит гүйцэтгэлээр гарсан.

№	Зардлын төрөл	2024 гүйц	2025 он		Зөрүү	
			Тод төлөв	Гүйц	Гүйц-Төлөв	Өнгөрсөн оноос
1	Цалин	374.7	664.4	565.9	(98.5)	191.2
2	НДШимтгэл	54.2	96.3	76.3	(20.0)	22.1
3	Томилолт	14.2	339.0	8.8	(330.1)	(5.4)
4	Шатахуун	23.0	31.8	20.1	(11.7)	(2.9)
5	Бичиг хэрэг	-	0.2	0.1	(0.0)	0.1
6	Холбоо	-	0.4	-	(0.4)	-
7	ХХ-ын зардал	-	-	0.1	0.1	0.1
8	Хангамжийн материал	14.4	15.0	9.9	(5.1)	(4.5)
9	Нийгмийн зардал	-	-	6.0	6.0	6.0
10	Элэгдэл	-	24.2	25.6	1.4	25.6
Захиргаа дүн		480.5	1,171.3	712.9	(458.4)	232.4
1	Цалин	144.6	145.2	145.2	-	0.6
2	НДШимтгэл	18.0	20.8	15.9	(4.9)	(2.1)
3	Томилолт	7.3	12.3	10.5	(1.8)	3.2
4	Бичиг хэрэг	0.3	0.2	0.1	(0.2)	(0.2)
ТУЗ дүн		170.2	178.6	171.7	(6.9)	1.5
1	Газрын төлбөр	202.2	202.3	202.2	(0.1)	(0.0)
2	Автын татвар даатгал	12.6	15.8	15.2	(0.6)	2.6
3	Аудит	32.2	39.2	39.2	-	7.0
4	ЭХЗХ	301.9	375.0	375.0	0.0	73.1
5	Эрчис Монгол	-	233.5	234.1	0.6	234.1
6	Гишүүнчлэл, үнэт цаас	-	-	-	-	-
7	Үл хөдлөх хөрөнгө	336.6	393.9	293.8	(100.2)	(42.9)
8	Усны нөөц ашиглалтын төлбөр	200.4	177.0	181.8	4.8	(18.6)
9	Агаарын бохирдлын төлбөр	28.1	28.7	27.2	(1.5)	(0.9)
Ерөнхий зардал дүн		1,113.9	1,465.5	1,368.4	(97.1)	254.5
ДҮН		1,764.6	2,815.3	2,253.0	(562.4)	488.4

Сургалтын зардал: Сургалтанд 79.7 сая төгрөг төлөвлөснөөс 73.2 сая төгрөгийг зарцуулсан. Нийт ажилтнуудад батлагдсан сэдвийн дагуу техникийн хичээл, дулаан механикийн тоноглолд ажиллах ААД, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, Гамшгийн тухай хууль, эмнэлгийн анхны тусламж, ХАБЭА-н хууль, эрсдэл, аюулыг илрүүлэх чиглэлээр, мөн цахилгаан тоноглолын аюулгүй ажиллагааны анхан шатны сургалтыг зохион байгуулав. Сургалтанд хамрагдсан ажилтнуудаас хуваарийн дагуу ээлжит бус шалтгалтыг зохион байгуулав. 2025 оны байдлаар зөвлөх инженер 5, зөвлөх эдийн засагч 1, мэргэшсэн инженер 9, мэргэшсэн нягтлан бодогч 7, төсөвчин 4 ажиллаж байгаа нь нийт удирдах болон ИТА-ны 20.8% байна. Дагалдуулан сургах багш, шавийн нийт 22 гэрээг байгуулан ажилласан байна. Эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран:

- 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 21-ний өдрийг дуусталх хугацаанд өргөх, тээвэрлэх машин, механизмын бүрэн бүтэн байдал хариуцагч, ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч, оосорлогч, дохиочин нарын эрх олгох, сунгах сургалтыг "Чадамж боломж" сургалтын төвийн багш Ш.Алтантунгалагтай хамтран зохион байгуулж, нийт 193 ажилтныг хамруулав. Нийт

54 ажилтан өргөх, тээвэрлэх машин механизмаар ачааг шилжүүлэн зөөх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагчийн эрхээ сунгуулснаас гадна оосорлогч, дохиочны сургалтад нийт 139 ажилтан хамрагдсан бөгөөд 92 ажилтан оосорлогч, дохиочны эрхээ сунгуулж, 47 ажилтан шинээр эрх авсан байна.

- 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд **“Дөрвөлжийн их бууц”** сургалтын төвийн багш Д.Баттөмөртэй хийсэн гэрээний дагуу **“Зуух, даралтат сав, шугам хоолойн ашиглалт, аюулгүйн ажиллагааны дүрэм”** сэдэвт сургалтыг улсын ахлах байцаагч М.Анхбаярын хяналт дор зохион байгуулж, нийт 204 ажилтныг хамруулан мэргэшлийн үнэмлэхний хугацааг тэмдэглэлээр баталгаажуулж, сунгав.
- “ХЭМАБ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ” ХХК-тай байгуулсан ЕРР/25У-41 дугаартай ажил үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу компанийн хэмжээнд нийт ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бүтэн өдрийн буюу нийт 6 цагийн гэрчилгээ олгох сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 14, 15, 21, 22, 23-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Борлуулалтын шимтгэл: 122.2 сая төгрөг хэтэрсэн. 2025 оны 01, 02 сард ЭХХХ-ны 2024 оны 36 тоот, 2025 оны 03-12 сард 2025 оны 71 тоот тогтоолоор шимтгэл хураамжийг Эрдэнэт Ус ДТСОНӨХК-д үлдээсэн. 2025 оны 71 тоот тогтоолоор “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тарифыг борлуулалтын (НӨАТ-гүй) 100 төгрөгийн орлого тутам 44 төгрөг 80 мөнгөөр баталсан. 2025 онд “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-аар дамжуулан 12,309.4 сая төгрөгийн борлуулалт хийж, засвар үйлчилгээний шимтгэлд 5,270.4 сая төгрөгийг үлдээсэн байна. Энэ нь төлөвлөсөн борлуулалтын орлого 299.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шимтгэлийн зардал 100.7 сая төгрөгөөр, шимтгэлийн хувь хэмжээний өсөлтөөс 21.5 сая төгрөг нэмэгдсэн.

Ажиллагсдын нийгмийн зардал: 2,459.8 сая төгрөг төлөвлөж, 2,547.1 сая төгрөг зарцуулж 87.2 сая төгрөгөөр хэтэрсэн.

№	Зардлын төрөл	2024 Гүйц	2025 он		Зөрүү	
			Төлөв	Гүйц	Гүйц-Төлөв	Өнгөрсөн оноос
1	Ажиллагсдын хоолны хөнгөлөлт /НДШ-ийн хамт/	657.5	783.1	702.9	(80.1)	45.5
2	Ажиллагсдын түлшний хөнгөлөлт	52.4	51.0	50.0	(1.0)	(2.4)
3	Ажиллагсдын унааны хөнгөлөлт	2.8	5.0	-	(5.0)	(2.8)
4	Ажиллагсдад олгосон тусламж,тэтгэмж, нөхөн олговор	1,122.5	1,485.5	1,794.2	308.7	671.7
5	Ажиллагсдад олгосон шагнал урамшуулал	91.1	-	-	-	(91.1)
6	Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээний зардал	74.5	-	-	-	(74.5)
7	Ахмадын сан	-	135.4	-	(135.4)	-
ДҮН		2,000.8	2,459.8	2,547.1	87.2	546.3

Хоолны хөнгөлөлт. Ажилтны нэг өдрийн хоолны хөнгөлөлт 2025 оны 01-09 дүгээр сард 5,500 төгрөг, 10 сараас 6,500 төгрөгөөр тооцон нийт ажиллагсдыг хамруулан олгосон.

Унааны хөнгөлөлт. Ажилчдын автобусны чиглэлээс зайдуу оршин суудаг 9 ажилтанд өдрийн 2,000 төгрөгөөр тооцон унааны хөнгөлөлт олгохоор төлөвлөсөн.

Түлшний хөнгөлөлт. 434 ажилтанд нэг ажилтны 100,000 төгрөгөөр тооцон түлшний хөнгөлөлт олгов.

Тэтгэмж, тусламж. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд өөрчлөлт орсноор 2025 оноос тэтгэмжийн мөнгийг Эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд 2,534,400 /792.0*1.6*2/ төгрөгөөр, Тарифын хэлэлцээрт өөрчлөлт орсноор Эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд 2,692,800 /792.0*1.7*2/ төгрөгөөр тус тус тооцон 18 ажилтанд 1,370.9 сая төгрөгийн тэтгэмж олгогдсон. Орон сууцны хөнгөлөлт олгогдсон. Насны ойн шагналд 31.2 сая төгрөг олгосон.

Тайлангийн хугацаанд өндөр насны тэтгэвэрт 20 ажилтан, өөрийн хүсэлтээр 31 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн. 64 хүн шинээр ажилд орсоны 1 ажилтан хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон. Шинэ ажилтнуудын 24 ажилтан нь дээд боловсролтой, 40 ажилтан нь тусгай мэргэжлийн болон бүрэн дунд боловсролтой.

2025 онд Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журмын дагуу 25 ажилтанд сахилгын шийтгэл оногдуулсан. Үүнд:

Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах 2,
 Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах 12,
 Үндсэн цалинг 1 сар 5 хувиар бууруулах 1,
 Үндсэн цалинг 1 сар 10 хувиар бууруулах 1,
 Үндсэн цалинг 1 сар 20 хувиар бууруулах 7,
 Үндсэн цалинг 2 сар 20 хувиар бууруулах 1,
 Үндсэн цалинг 3 сар 20 хувиар бууруулах 1,

Үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаа: Тайлант хугацаанд **1,382.2** сая төгрөгийн орлого орж **333.7** сая төгрөгийн зардал зарцуулж **1,048.5** сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зорилтот түвшингийн биелэлт:

Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны тодотгосон төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	2025 Гүйцц - 2025 Төлөв	Биелэлт
			х	1	2	3	4=3-2	
1	Үйлдвэрлэсэн: ЦЭХ		сая.квтц	432.1	405.3	404.9	(0.4)	98.5%
	Үйлдвэрлэсэн: ДЭХ		мян.Гкал	699.6	703.2	703.8	0.6	
	ДХЦЭХ	Хувиар	хувь	13.59%	14.04%	14.66%	0.62%	
		Биетээр	сая.квтц	58.7	56.9	59.3	2.4	
	Түгээсэн: ЦЭХ		сая.квтц	373.4	348.4	345.5	(2.9)	
	Түгээсэн: ДЭХ		мян.Гкал	647.0	651.7	651.8	0.1	
2	Нийт орлого		сая.төг	90,640.1	97,350.9	98,876.2	1,525.3	101.6%
	Үүнээс:	Үйл/а-ны орлого	сая.төг	83,692.2	97,159.1	97,494.0	334.9	
		Улсын төсвийн санхүүжилт	сая.төг	5,968.1	-	-		
		Үйл/а-ны бус орлого	сая.төг	979.9	191.8	1,382.2	1,190.4	
3	Нийт зардал		сая.төг	90,326.7	111,825.6	104,820.3	(7,005.3)	106.7%
	Үндсэн үйл/а-ны зардал		сая.төг	89,283.7	111,346.1	104,486.6	(6,859.5)	
	Үүнээс:	Түлш	сая.төг	36,793.1	42,354.8	40,584.4	(1,770.4)	
		Элэгдэл	сая.төг	6,638.9	10,515.2	9,900.3	(614.9)	
		Бусад тогтмол	сая.төг	45,851.6	58,476.2	54,002.0	(4,474.2)	
	Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	1,043.0	479.5	333.7	(145.8)	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	313.4	(14,474.7)	(5,944.1)	8,530.6	243.5%
5	Татварын дараахь ашиг/алдагдал		сая.төг	266.4	(14,494.7)	(5,944.1)	8,550.6	
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.00	1.15	1.06	(0.09)	108.4%
7	Нийт авлага		сая.төг	5,604.6	818.9	11,561.3	10,742.4	7.1%
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	4,500.1	818.9	10,025.9	9,207.0	
		бусад	сая.төг	1,104.5	-	1,535.4	1,535.4	
8	Нийт өглөг		сая.төг	16,340.2	188,000.5	231,097.5	43,097.0	81.4%
	Үүнээс:	БХӨТ	сая.төг	15,532.5	11,300.5	66,546.6	55,246.1	
		УХӨТ	сая.төг	807.7	176,700.0	164,550.9	(12,149.1)	
9	Нийт ажиллагсад		хүн	465	473	471	(2)	99.6%
10	Нийт цалингийн сан		сая.төг	22,608.3	26,330.6	26,229.2	(101.4)	100.4%
11	ЖТХЗ	ЦЭХ	гр/кВт.ц	415.25	406.54	404.47	(2.1)	100.4%
		ДЭХ	кг/Гкал	189.08	187.44	187.04	(0.4)	
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	7,637.3	11,885.6	10,782.4	(1,103.1)	96.2%

Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт, гэрээний талаар

№	Зардлын төрөл	2025 оны төлөвлөгөө		2025 төлөвлөгөөний гүйцэтгэл		Биелэлт
		тоо	сая.төг	тоо	сая.төг	хувь
1	Үндсэн, туслах тоноглолын их засвар	26	8,960.4	25	8,413.6	98.1%
2	ТЗБАХ	9	932.6	8	851.9	95.6%
3	Хөрөнгө оруулалт	49	1,992.5	46	1,517.0	95.1%
Нийт ИЗ, ТЗБАХ, ХО-н дүн		84	11,885.6	79	10,782.5	96.2%

2025 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зардалд 11,885.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний үзүүлэлтэд үндэслэн 2025 оны бизнес төлөвлөгөөг ЭХЯ баталсан.

1. Эрчим хүчний сайдын 2025 оны 08-р сарын 07-ны өдрийн А/186 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар үнийн дүнд өөрчлөлт оруулалгүйгээр, ажлын бүтцэд өөрчлөлт оруулан 84 ш ажлыг 11,885.6 төгрөгт хийхээр төлөвлөгөөг тодотгосон.

Тодотгосон төлөвлөгөөгөөр:

- **Их засварын ажлаар:** нийт 23 нэр төрлийн 26 ажлыг 8,960.4 сая төгрөг
- **ТЗБАХ-ний ажлаар:** нийт 7 нэр төрлийн 9 ажлыг 925.6 сая төгрөг
- **Хөрөнгө оруулалтын ажлаар:** нийт 49 ширхэг тоног төхөөрөмж авахаар 1,192.6 сая төгрөг, нийт 11,885.6 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсан.

Жилийн эцсийн гүйцэтгэлээр:

- Үндсэн тоноглолын их засварын 3 нэр төрлийн ажлаас 3 ажил 100%-тай, Туслах тоноглолын 20 нэр төрлийн 23 ширхэг ажлаас 19 нэр төрлийн 22 ажил 100%-тай хийгдэж дууссан, 1 нэр төрлийн 1 ажил 50%-ийн гүйцэтгэлтэй, Их засварын нийт гүйцэтгэл 98.1% хувьтай.
- ТЗБАХ-ний 7 нэр төрлийн 9 ажил төлөвлөгдсөнөөс 8 ажил бүрэн 100%-тай хийгдэж дууссан. 1 ажил материал нийлүүлэлт оройтсонтой холбоотойгоор он дамнасан. ТЗБАХ-ийн гүйцэтгэл 95.6% хувьтай.
- Хөрөнгө оруулалтын 33 нэр төрлийн 49 ширхэг тоног төхөөрөмжөөс 30 нэр төрлийн 46 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 95.1% хувьтай.

Нийт 2025 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын төлөвлөгөөний биелэлт 96.2%-ийн гүйцэтгэлтэй.

Туслах тоноглолын дутуу ажил:

- **“Станцын удирдлагуудын өрөөний их засвар”-ын ажилд** “Талст өргөө” ХХК шалгаран 10-р сарын 02 -ны өдөр ЕРР/25А-22 тоот гэрээг байгуулсан. (2025 оны 11 дүгээр сарын 25-аас хуанлийн 40 хоногт багтаан гүйцэтгэх). Их засварын ажил 2025 оны 12-р сарын 25-ниас эхэлсэн, 50%-тай ажил үргэлжилж байна.

Техник зохион байгуулалтын арга хэмжээний ажил:

- **“Вагон хөмрөгчийн бутлагч фрезерийн машин ДФМ- 1 хөдөлгүүр редукторууд, цахилгааны кабель удирдлагын хэлхээг бүрэн шинэчлэх засвар”-ын ажлыг** 2025 оны 08-р сарын 08-ны өдөр “Нүүдэлчин мон агро” ХХК хуанлийн 60 хоногт гүйцэтгэх ЕРР/25А-16 тоот гэрээг байгуулсан. Уг ажлын материалаас 2025 оны 10-р сарын 15-ны өдөр ирсэн 3ш хөдөлгүүр, 3ш редуктор нь техникийн тодорхойлолтын дагуу ирээгүй ороогдсон хөдөлгүүр, хуучин редуктор ирсэн тул буцаагдсан. Тухайн компани 2025 оны 12-р сарын 16-ны өдөр шинээр хөдөлгүүр, редуктор нийлүүлэн ажил эхлэх зөвшөөрөл хүссэн. Станцын өвлийн оргил ачаалал эхэлсэн 7 зуухны горимоор ажиллаж, тоноглол зогсоох боломжгүй, их засварын ажлыг 2026 оны 04-р сарын 01-нээс эхлүүлэхээр хойшлуулсан.

Хөрөнгө оруулалт:

- Дренажны бакны насос №2 K-45-55 насосыг евростандартын грундфосс насосоор солих /TP 80-400/2 A-F-A-BAQE-OW1 давтамж хувьсгуургүй / "Алтанцомбон" ХХК шалгаран 05-р сарын 14 нд хуанлийн 90 хоногт нийлүүлэхээр EPP/25Б-24 тоот гэрээг байгуулсан. Тухайн компаниас 2025 онд 2 удаа насос ирж, техникийн шаардлага хангаагүй тул буцаагдсан. **20%**
- Зуух №2-ын компьютерын хяналт удирдлагын системийн материал "Хэрлэнгийн боргио" ХХК нийлүүлсэн. Материал нийлүүлэлт оройтож 2025 оны 12-р сарын 04-ний өдөр нийлүүлэгдсэн. Тухайн материалуудаас 2 ширхэг контроллёрын ажиллагаа шалган шаардлага хангахгүй байсан тул буцаагдсан. Материал нийлүүлэлт **98%**-тай тул гэрээ дүгнэгдээгүй байна.
- Том оврын хүн тээврийн автобус "Хазаарбат" ХХК шалгаран хуанлийн 60 хоногт нийлүүлэхээр EPP/25Б-08 тоот гэрээг байгуулсан. Гэрээний хугацаа дууссан, тухайн компани 2026 оны 01-р сарын 15нд нийлүүлэхээр байна. **20%**
- Toyota Prius 55, 2019/2025 маркийн автомашин "Бринг торч" ХХК хуанлийн 60 хоногт нийлүүлэхээр 11-р сарын 27нд гэрээ хийсэн. Гэрээний хугацаа хүлээж байна. **20%**
2026 оны 01-р сарын 20-нд нийлүүлэгдэнэ.

№	Тендер шалгаруулалтын арга	2025 оны тодотгосон төлөвлөгөө		2025 оны гүйцэтгэл		Биелэлт
		Тоо /ш/	Мөнгөн дүн /сая төг/	Тоо /ш/	Мөнгөн дүн /сая төг/	
1	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	34	14,609.16	33	12,936.07	93.8%
2	Харьцуулалтын арга	47	3,015.38	47	2,849.85	94.0%
3	Нэг эх үүсвэрээс худалдан авалт	6	45,813.70	6	44,013.18	100.0%
4	Шууд худалдан авалт	159	1,587.73	143	1,284.44	99.3%
	ДҮН	246	65,025.97	229	61,083.53	96.8%

ТБОНӨХБАҮХАвах тухай хуулийн дагуу бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтын үйл ажиллагаа явагдаж байна. Худалдан авалтын төлөвлөгөө 96.8%-н биелэлттэй. 2024 оны төсөл арга хэмжээнээс 2025 онд 869.8 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, 2025 оны төсөл арга хэмжээнээс 2026 онд 3,640.3 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжинэ. Тайлант хугацаанд нийт 154 гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээтэй холбоотой зөрчилгүй.

2024 оны жилийн эцсийн тайлан балансаар тавигдсан зорилтуудаас дараахи ажлууд хийгдэв.

- Жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, холбогдох дээд газруудад өгсөн.
- 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын А/12 тушаалаар батлав.
- 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын А/186 тушаалаар тодотгосон.
- 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын А/273 тушаалаар тодотгосон.
- "Шилэн данс" сайт болон "Шилэн данс", "Санхүүгийн ил тод байдал" самбарт мэдээллийг тогтмол шинэчилж ажиллаж байна.
- Орхон аймгийн Төрийн аудитын газар компанийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийсэн ба "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөв.
- Өргөтгөлийн балансад бүртгэсэн.
- ЭХЗХороо Үнэ тариф:
 - ЭХЗХорооны 03 дугаар сарын 24-ны өдрийн 57 тоот тогтоолоор энергийн тариф 111.17 төг/кВт.ц, чадлын тариф II,III улиралд 3,015,017 мян.төг/сар, IV улиралд 4,275,903 мян.төг/сар болж батлагдсан.

ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ.

- Бараа материалын насжилтанд анхаарч кодчилогыг бодлогыг сайжруулж барааны үлдэгдэлд анхаарч агуулахуудын эмх цэгц, хаягжилт сайжруулж нөөцийг зохистой хэмжээнд байлгах.
- Эргэлтийн бус хөрөнгийн бүртгэл болон кодчилогыг сайжруулах, Төрийн өмчийн программчлалд нэвтрэх.
- Батлагдсан бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж ажиллах.
- Дансны төлөвлөгөө, зардлын кодчилогыг шинэчлэх.

- Аудитын зөвлөмжийг бүрэн биелүүлэх
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг бодох.
- Үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэх

Ерөнхий нягтлан бодогч, СБЭЗХ-ийн дарга:...../Б.Зулцэцэг/

